

ОЮУТНЫ ЭНТРЕПРЕНЁР БОЛОХ ЗОРИЛГОД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН СУДАЛГАА

A study on factors affecting student's entrepreneurial intention

З.Алтанчимэг*, Н.Сонинтамир**, Ц.Болортуяа***

Хураангуй: Энтрепренёр чиг баримжаатай жижиг, дунд бизнесүүд улс орны баялаг, ажиллах хүчний дийлэнхийг бүтээж, хурдан өсөн дэвшиж, дэлхийн хэмжээний том бизнесүүдийг бий болгож, эсвэл тэдний гол түншүүдийн нэг болж байгаа учраас дэлхий даяар өсвөр үеийн залуусын энтрепренёрын зорилго, түүнд нөлөөлөх хүчин зүйлс, энтрепренёр боловсрол, хандлагын талаарх судалгаа нилээдгүй хийгдэж байна.

Иймд оюутан залуус өөрсдийн гарааны бизнесээ эхлүүлэх хүсэл сонирхол байгаа эсэх, их сургуулийн зүгээс энтрепренёрт хандах хандлага, мэдлэгт нөлөөлж байгаа эсэх болон тэднийг ирээдүйд өөрсдийн бизнестэй болох хүсэл зорилготой болгож байгаа эсэхийг тодорхойлох нь зайшгүй хийгдэх ёстой судалгаануудын нэг болоод байна.

Оюутны энтрепренёр болох зорилгод хандлага, субъектив хэм хэмжээ, төсөөллийн зан төлөвийн хяналт, энтрепренёр боловсрол зэрэг хүчин зүйлийн нөлөөллийг судлах зорилгоор А сургуулийн 336 оюутнуудаас санамсаргүй түүврийн аргаар сонгон санал асуулга явуулсан.

Судалгааны үр дүнгээс харахад энтрепренёрт хандаж буй хувийн хандлага нь энтрепренёр болох зорилгод мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг бөгөөд оюутан залуус бизнес эрхлэх боломж л гарвал өөрийн бизнесээ эхлүүлэх хүсэл сонирхолтой, өөрийн гэсэн бизнестэй байх нь олон давуу талуудыг өөртөө бий болгодог хэмээн үзсэн. Субъектив хэм хэмжээ болон төсөөллийн зан төлөвийн хяналт энтрепренёр болох зорилгод эерэг, ижил төвшний нөлөө үзүүлсэн бол энтрепренёр боловсролын энтрепренёр болох зорилгод үзүүлж байгаа нөлөө бусад хүчин зүйлсээс статистик ач холбогдол бага гарсан.

Түлхүүр үг: Энтрепренёр болох зорилго, хандлага, субъектив хэм хэмжээ, төсөөллийн зан төлөвийн хяналт, энтрепренёр боловсрол

Abstract: Small and medium sized businesses with entrepreneur orientation have been developing rapidly creating wealth of the nations and often become larger global enterprises. The growing trend boosts researches on the entrepreneur intention, entrepreneur education, attitude as well as the factors affecting to the them.

Considering the circumstances, the study on whether the university is nurturing the entrepreneur intention, attitude and willingness to start their

* МУИС-ийн Бизнесийн сургууль, (Email) zaltanchimeg@gmail.com

** МУИС-ийн Бизнесийн сургууль, (Email) sonintamir@gmail.com

*** МУИС-ийн Бизнесийн сургууль, (Email) tuyachka89@gmail.com

own businesses is getting essential.

The current study aimed at researching numerous factors affecting entrepreneur intention and attitude of the students, subjective norms, entrepreneur education, perceived behavior control using sample survey involving 336 university students.

The survey results showed that the personal attitude had a slight influence on entrepreneur intention and the students expressed that they had an intention starting their own business immediately if they have an opportunity and they were pretty aware about the benefits of owning their own businesses.

Subjective norms and perceived behavior control demonstrated both positive influences to becoming an entrepreneur, but an entrepreneur education presented low statistical significance in the study.

Key words: Entrepreneurial intention, theory of Planned Behavior, attitude, subjective norm, perceived behavioral control, entrepreneurial education

Удиртгал

Аливаа үндэстний хөгжлийн хамгийн сайн стратегиудын нэг нь энтрепренёршип хэмээн үнэлэгдэж олон улс орнууд стартап бизнесийг бодлоготойгоор хөхүүлэн дэмжиж байна. Энтрепренёршип нь эдийн засаг талаасаа төдийгүй нийгэм талаасаа ч хөгжлийн олон асуудлыг нааштайгаар шийдэхэд чухал нөлөө үзүүлдэг байна. (Storey.D.J, 1994). Энтрепренёршиппийг дэмжсэнээр ажлын байрыг нэмэгдүүлэх, нэг салбараас хэт хамаарсан байдлыг бууруулах, хөрөнгө оруулалтын урсгал болон бизнесийн орчинг дэмжих, ирээдүйн том аж ахуйн нэгжийн үндсийг тавих, нэгэнт төлөвшсөн компаниуд оутсорсинг ашиглан үйл ажиллагаагаа илүү үр ашигтай, үр дүнтэй зохион байгуулах, шинэлэг санаа, инновацийг хөгжүүлэх зэрэг олон ач холбогдолтой юм.

Монгол улсад сүүлийн жилүүдэд шинэ технологи, инноваци дээр суурилсан шинэ санаа хөгжүүлэгч стартап компаниуд бий болж, хөгжиж эхэлсэн хэдий ч их сургуулийн төгсөгчдийн ажил эрхлэлт, залуусын ажилгүйдэл нь тулгарч байгаа нийгмийн чухал асуудлуудын нэг хэвээр байна. Иймд, их сургуулиудын энтрепренёршиппийн сургалт, хөтөлбөрийг боловсронгуй болгох, энтрепренёр сэтгэлгээтэй хүний нөөцийг бэлтгэх хэрэгцээ шаардлага байгаа бөгөөд үүнд их дээд сургуулиудын үүрэг оролцоо маш их билээ.

Энхүү судалгааны зорилго нь оюутны энтрепренёр болох зорилгод энтрепренёрт хандах хандлага, субъектив хэм хэмжээ, төсөөлсөн зан төлөвийн хяналт, энтрепренёр боловсрол зэрэг хүчин зүйлийн нөлөөллийг судлахыг зорьсон.

НЭГ. ЭНТРЕПРЕНЁР БОЛОХ ЗОРИЛГО БА ТҮҮНИЙГ ТОДОРХОЙЛОХ ЗАГВАРУУД

Энтрепренёр. “Entrepreneur” гэсэн нэр томъёо нь “entreprendre” гэсэн үгнээс гаралтай Франц үг юм. Тус нэр томъёог судлаачид олон янзаар үгчилэн тайлбарлах ба хоёр хэсгээс бүрдэх “entre” – “between”, “preneur” – “taker” буюу between- taker мөн undertake гэсэн утгатай гэж үзэж байна.

Австрийн нэрт эдийн засагч, суут сэтгэгч Joseph Alois Schumpeter “Энтрепренёрын үйл ажиллагаа нь шинэ бүтээлийг ашиглах замаар үйлдвэрлэлийн талаар шинэчлэлт, өөрчлөлт хийх явдал буюу ерөнхийдөө шинэ бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн туршиж үзээгүй технологийг, материал нийлүүлэх шинэ эх үүсвэрийг нээх, шинэ үйлдвэрийг зохион байгуулж шинэ гарцыг нээх мөн одоо байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээний байгаа байдлыг эвдэх замаар шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгодог” гэж тодорхойлжээ (Anurag Pahuja, 2015).

Ийнхүү энтрепренёрын үйл ажиллагааг тодорхойлохоос гадна уг үйл ажиллагааг эрхлэгч субъектыг мөн олон талаас нь тодорхойлсон байдаг, Тухайлбал Knight (1921) and Ducker (1985) нар энтрепренёр нь эрсдэл хүлээгч, Hisrich (1990) энтрепренёр бол санаачилга, бүтээлч сэтгэлгээг харуулсан хүн бөгөөд эрсдэл болон алдааг хүлээн зөвшөөрч, нөхцөл байдлыг практикт тооцоолж нийгэм эдийн засгийн механизмыг зохион байгуулагч, Bolton and Thompson (2004) нар инноваци болон шинийг сэтгэж, үнэ цэнийг бий болгодог хүн гэж тодорхойлжээ.


Энтрепренёрыг хамгийн энгийнээр, төлөвлөсөн өгөөжөө хүртэхийн тулд өөрийн аж ахуйг эхлүүлэх, хэрэгжүүлэх, үүний тулд өөрийн оюун ухаан, ур чадвар, эд баялгаа нэгтгэн хүчин чармайлт гаргаж буй хүн юм (Hitesh S.Viramgami, 2007) гэж үзэж болно.

Энтрепренёр болох зорилго (Entrepreneur intention) нь хувь хүний төлөвлөгөө, ялангуяа бизнес төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийг удирдан чиглүүлэх оюуны үйл явц (Gupta and Bhawe, 2007). Энтрепренёр болох шийдвэр нь сайн дурын болон ухамсартайгаар гардаг ба энэ шийдвэр хэрхэн гардгийг энтрепренёр болох зорилгын онолын загвараар судлагдаг. Энэ утгаараа энтрепренёр болох зорилго нь энтрепренёрын зан төлөвийн гүйцэтгэлийг тодорхойлох элемент байх бөгөөд тухайн зан төлөвийг гүйцэтгэх зорилго нь хувь хүний хандлагаас хамаарна.

Энтрепренёрын болох зорилгыг хувь хүний дотоод шинж чанар болон гадны хүчин зүйлсийн нөлөөгөөр судлах ба ихэвчлэн “Энтрепренёр үйл ажиллагааны загвар” (Sharero & Sokol, 1982), “Антрепренёр болох санааг хэрэгжүүлэх загвар” (Bird, 1988), “Төлөвлөгдсөн зан төлөвийн онол” (Azjen, 1991,2002), “Энтрепренёр чиг хандлагын загвар” (Robison.P.B, Stimpson.D.V, Huefner.J.C, Hunt.H.K, 1991), “Энтрепренёр болох зорилгын загвар” (Krueger, 1993), “Хүлээгдэж буй онолын загвар” (Boyd, Vozikis, 1994), зэрэг онол, загваруудыг баримтладаг байна.

Төлөвлөгдсөн зан төлөвийн онол. Төлөвлөгдсөн зан төлөвийн онол нь энтрепренёр болох зорилгыг тодорхойлоход хамгийн өргөн ашиглагдаж байгаа онол бөгөөд эрдэмтэн Azjen болон Madden нарын “Учир шалтгаант үйл явцын онол”-д тулгуурлан хөгжүүлэн гаргажээ. Тодорхой зан төлөвийг гүйцэтгэх зорилго болон бодит гүйцэтгэлийн хооронд хүчтэй хамаарал байх ёстой гэж үздэг бөгөөд зорилго нь зан төлөвийг илэрхийлэгч гол хэмжүүр юм. Зорилго нь хүний ямар нэгэн зан төлөвийг гүйцэтгэх мотивацийг илэрхийлэх бөгөөд зорилго хүчтэй байх тусам тухайн зан үйлийг гүйцэтгүүлэх магадлал их байдаг байна. Зорилгод нөлөөлөх гурван элемент нь зорилгыг тайлбарлах хувьсагчдыг бүрдүүлэх ба элементүүдийн хоорондын харилцан хамаарал байгаа гэж үздэг.

Зураг 1. Төлөвлөгдсөн зан төлөвийн онолын загвар



Эх сурвалж: Ajzen, I, 1991 “Organizational Behavior and Human Decision Processes”, 50(2), 179–211

Тухайн зан төлөвт чиглэгдсэн хувийн хандлага (Attitude toward behavior) - Тодорхой нэг зан төлөвийг гаргаснаас болж үүсэх эерэг болон сөрөг мэдрэмжийн түвшинг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл тухайн зан төлөвийг гүйцэтгэхэд гарах үр дүнд нь тухайн хүнд эерэг мэдрэмж бий болгох уу? үгүй юу гэдгээр илэрхийлэгдэнэ (Ajzen, 2002, Kolvereid, 1996). Хандлага нь тодорхой үр дүн, тухайн байр байдалд хандах зан чанаруудаар тодорхойлогдох ба хандлагад хувь хүний ур чадвар, зан чанарууд нөлөөлж болно. Хувийн зан чанар буюу эрсдэл хүлээх чадвар, зорилгодоо хүрэх хандлага, гэсвэр гэвчээртэй байдал гэх мэт хүчин зүйлс болно..

Субъектив хэм хэмжээ (Subjective norms) - Бусдын хандлага болон итгэлээр тайлбарлагдах ба тухайн хүний хүрээлэлд байгаа хүмүүсийн итгэл үнэмшил, дэмжлэгтэй холбоотой. Өөрөөр хэлбэл тухайн зан төлөвт хандаж байгаа нийгмийн хандлагыг хэрхэн хүлээж авч байгаатай холбоотой бөгөөд нийгмийн хандлага эерэг, дэмжлэг их бол энтрепренёр болох зорилго улам хүчтэй болж эсрэгээрээ нийгмийн хандлага сөрөг, эсэргүүцэл их бол зорилго буурдаг байна (Ajzen, 2001).

Төсөөлсөн зан төлөвийн хяналт (Perceived behavior control) - Төлөвлөгдсөн зан төлөвийн онолын загвараар төсөөлсөн зан төлөвийн хяналт нь тодорхой нэг зан төлөвийг биелүүлэхэд саад болдог, хориглодог хүчин зүйлсүүдийн цогцоор тодорхойлдог гэж үздэг. Өөрөөр хэлбэл, зан төлөвийг гүйцэтгэхэд хялбар эсвэл хүндрэлтэй юу гэсэн хувь хүний ойлголт юм. Энэхүү “Төсөөлсөн” гэдэг утга нь хувь хүний өнгөрсөнд хуримтлуулсан туршлага, ирээдүйд учрах саад бэрхшээлийг даван туулах чадвараар тодорхойлно (Christian Willi Scheiner, 2009). Тухайн хүн илүү их туршлага хуримтлуулж, шаардлагатай ур чадварт

суралцаж, мэдлэг ур чадвартай болох тусам өөртөө итгэлтэй болж тухайн зан төлөвийг гүйцэтгэх зорилго улам хүчтэй болдог байна.


Энтрепренёр боловсрол (Entrepreneurial education). - Krueger and Carsrud (1993) нар Төлөвлөгдсөн зан төлөвийн онолыг бизнес эрхлэгчдийн боловсролын онцлогтой холбож үзээд энтрепренёр болох зорилгод тухайн хүний бизнесийн талаарх мэдлэг, боловсрол нөлөөлж болохыг тодорхойлсон. Gorman, Hanlon болон King, (1997) нар энтрепренёр боловсрол нь хүмүүсийг хариуцлагатай, санаачлагатай хувь хүн болгоход чиглэгддэг ба бизнес эрхлэх зорилгоо биелүүлэхэд шаардлагатай хандлага, ур чадвараа хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлдэг хөтөлбөр юм.

Liñán (2004) энтрепренёр талаарх мэдлэг, боловсрол нь бизнес эрхлэгч болох хүсэл эрмэлзэлийг нэмэгдүүлдэг бөгөөд тэрээр Ajzen-ийн “Төлөвлөгдсөн зан төлөвийн онол” (1991), Sharero болон Sokol нарын “Энтрепренёр үйл ажиллагааны онол” (1982) хоёр онолыг боловсролын үйл ажиллагаагаар дамжуулан олж авсан энтрепренёр талаарх мэдлэг боловсрол гэсэн элементийг нэмж өөрийн загвараа боловсруулсан. Энтрепренёр боловсрол нь шинийг санаачлах, чөлөөтэй сэтгэх, бизнес эрхлэх ур чадваруудад суралцах, өөрийн нөөц бололцоог нээн илрүүлэхэд тусалдаг.

ХОЁР. СУДАЛГААНЫ ЗАГВАР, ҮР ДҮН

Энтрепренёр болох зорилго ба түүнийг тодорхойлох загваруудад үндэслэн бид дараах загварыг боловсруулан таамаглал дэвшүүлсэн.

Зураг 2. Судалгааны загвар



Судалгааны таамаглал:

H1: Хандлага нь энтрепренёр болох зорилгод эерэг нөлөө үзүүлнэ.

H2: Субъектив хэм хэмжээ нь энтрепренёр болох зорилгод эерэг нөлөө үзүүлнэ.


H3: Төсөөлсөн зан төлөвийн хяналт энтрепренёр болох зорилгод эерэг нөлөө үзүүлнэ.

H4: Энтрепренёр боловсрол нь энтрепренёр болох зорилгод эерэг нөлөө үзүүлнэ.

Судалгааны арга зүй. Оюутны энтрепренёр болох зорилгод хандлага, субъектив хэм хэмжээ, төсөөлсөн зан төлөвийн хяналт, энтрепренёр боловсрол зэрэг хүчин зүйлийн нөлөөллийг судлах зорилгоор А сургуулийн оюутнуудаас санамсаргүй түүврийн аргаар сонгон санал асуулга явуулж SPSS 23.0 программаар боловсруулалт хийж үр дүнг гаргав. Судалгааны санал асуулгыг 2019 оны 05 сарын 10-наас 05 сарын 20-ны өдрүүдэд явуулж, нийт 400 ш санал асуулгын хуудас таараагдснаас 378 ш (80.0%) хариулттай хуудсыг цуглуулан авч үүнээс шаардлага хангасан 336ш (70.8%) асуулгыг судалгаанд ашигласан. Санал асуулга 5 бүлгийн нийт 22 асуулт болон хүн ам зүйн хүчин зүйлийн 8 асуултаас бүрдсэн.

Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл. Судалгаанд оролцсон оюутнуудын 61% буюу 206 нь эмэгтэй, 39% буюу 130 нь эрэгтэй оюутан байсан бөгөөд Менежментийн тэнхимээс 106, Маркетинг, худалдааны тэнхимээс 70, Нягтлан бодох бүртгэлийн тэнхимээс 80, Санхүүгийн тэнхимээс 80 оюутан, мөн I төвшний 18, II төвшний 109, III төвшний 145, IV төвшний 68 оюутан тус тус хамрагдсан байна.


Зураг 3. Судалгаанд оролцогчдын суралцаж буй курс болон тэнхим



Эх сурвалж: Судлаачийн тооцооллоор

Оюутны энтрепренёр болох зорилгод суралцаж буй төвшний ялгаатай байдал нөлөөтэй эсэх талаар авч үзэхэд 4 дүгээр төвшний оюутнуудын энтрепренёр болох зорилго хамгийн өндөр дундаж утга 3.32, харин 2 дугаар төвшний оюутнуудын хувьд хамгийн бага буюу дундаж утга 3.09 байсан бол 1 болон 3 төвшний оюутнуудын хувьд дундаж утга 3.14-3.17 байсан.

Зураг 4. Суралцаж буй төвшин ба энтрепренёр болох зорилго



Эндээс дүгнэхэд энтрепренёр болох зорилго нь хэд дүгээр төвшинд суралцаж байгаагаас үл хамаарч байгаа нь харгадсан.

Оюутнуудын энтрепренёр сэтгэлгээг хөгжүүлэхэд нөлөө үзүүлж болохуйц Бизнес ба нийгэм, Бизнес төлөвлөлт, Төслийн менежмент, Жижиг дунд үйлдвэрлэлийн менежмент хичээлүүдийг сонгон судалсан эсэх нь энтрепренёр болох зорилгод нөлөөлөх талаар авч үзсэн. Үүнийг тулд сонгон судалсан хичээлүүдийн нөлөөг шалгахын тулд T test хийн үр дүнг (Хүснэгт 1)-д харуулаа.

Хүснэгт 1. Энтрепренёр болох зорилго, сонгон судалсан хичээлүүдийн нөлөөлж байгаа эсэх

	Хичээлийг сонгон судалсан			Хичээлийг сонгон судлаагүй			t	Sig. (2-tailed)
	n	Mean	Std. Error	n	Mean	Std. Error		
Бизнес ба нийгэм	223	3.07	.074	103	3.22	.125	-1.009	.314
Бизнес төлөвлөлт	63	3.62	.140	273	3.06	.072	1.990	.007
Төслийн менежмент	137	3.34	.096	199	3.05	.086	1.331	.005
Жижиг дунд бизнесийн менежмент	40	3.58	.170	296	3.11	.069	0.623	.010


Эх сурвалж: Судлаачийн тооцоолоор

Бизнес төлөвлөлт, Төслийн менежмент, Жижиг дунд бизнесийн менежмент

хичээлүүдийн хувьд тус хичээлийг судалсан оюутнууд нь судлаагүй оюутнуудтай харьцуулбал энтрепренёр болох зорилго өндөр байсан бөгөөд эдгээр хичээлээр олж байгаа мэдлэг, ур чадвар тодорхой төвшинд оюутнуудыг бизнес эрхлэгч болох сэдэл, зорилгод нөлөөлж байгааг харуулж байна. Харин Бизнес ба нийгэм хичээлийг сонгон судалсан оюутнуудын хувьд уг хичээлийг сонгон судлаагүй оюутнуудаас энтрепренёр болох зорилго доогуур түвшинд байсан.

Оюутнуудын амьдарч буй орчин энтрепренёр болох зорилгод нөлөө үзүүлж байгаа талаар судлахад гэртээ, түрээсийн байранд болон оюутны байранд амьдардаг оюутнуудын энтрепренёр болох зорилго өндөр буюу дундаж утга нь 3.02-3.28, харин хамаатныдаа амьдардаг оюутнуудын энтрепренёр болох зорилго нь бага буюу дундаж утга 2.69 байсан.

Зураг 5. Оюутнуудын амьдарч буй орчин энтрепренёр болох зорилго



Эх сурвалж: Судлаачийн тооцооллоор

Мөн гэр бүлийн гишүүд, ойр дотны хүмүүсээс хувиараа бизнес эрхэлдэг байдал оюутны энтрепренёр болох хүсэл эрмэлзэлд нөлөөлж байгаа эсэх талаар шалган T test хийн үр дүнг (Хүснэгт 2)-д харуулаа.

Хүснэгт 2. Энтрепренёр болох зорилгод гэр бүлийн гишүүд, ойр дотны хүмүүсээс хувиараа бизнес эрхэлдэг байдал нөлөөлдөг эсэх

	Гэр бүлийн гишүүд, ойр дотны хүмүүсээс хувиараа бизнес эрхэлдэг			Гэр бүлийн гишүүд, ойр дотны хүмүүсээс хувиараа бизнес эрхэлдэггүй			t	Sig. (2-tailed)
	n	Mean	Std. Error	n	Mean	Std. Error		
EI	229	3.28	.075	106	2.29	.115	3.562	.000

Эх сурвалж: Судлаачийн тооцооллоор

Аав, ээж, гэр бүл ойр дотны хүмүүс нь бизнес эрхэлдэг оюутнуудын энтрепренёр болох зорилго өндөр буюу дундаж утга 3.28 байсан бол ойр

дотны хүмүүс бизнес эрхэлдэггүй оюутнуудын энтрепренёр болох зорилго харьцангуй бага буюу дундаж утга 2.29 байсан. Энэ нь ойр дотны хүмүүсийн нөлөөлөл энтрепренёр болох зорилгод нөлөө үзүүлдэг болохыг харуулж байна.

Түүврийн хангалттай байдлын шинжилгээ. Түүвэр эх нь олонлогоо төлөөлж чадах эсэхийг харуулдаг үзүүлэлтийг КМО буюу Kaiser-Meyer-Olkin гэж нэрлэх бөгөөд энэ үзүүлэлт өндөр байх тусам түүврийн хангалттай байдлыг харуулна. КМО үзүүлэлтээс гадна Signification (Sig) үзүүлэлтийг шалгах ба энэ нь судалгааны алдаа гаргасан эсэхийг тодорхойлдог үр дүн юм. КМО нь шинжилгээ хийхэд түүврийн тоо хангалттай, хүрэлцээтэй эсэхийг хэмжих ба энэ нь 0.5-аас их байх ёстой. Түүврийн хангалттай байдлыг тодорхойлох Kaiser-Meyer-Olkin (КМО) болон Bartlett-ийн шинжилгээний үр дүнг (Хүснэгт 3)-д харуулав.

Хүснэгт 3. Түүврийн хангалттай байдлын шинжилгээний үр дүн

КМО and Bartlett's Test		
Kaiser-Meyer-Olkin Measure of Sampling Adequacy.		0.885
Bartlett's Test of Sphericity	Approx. Chi-Square	3406.370
	df	231
	Sig.	0.000

Эх сурвалж: Судлаачийн тооцооллоор

Шинжилгээний үр дүнгээс харахад КМО нь .885 байгаа нь түүврийн хэмжээ хүрэлцэхүйц байгаа буюу хангалттай, Bartlett's Test Sphericity Sig. .000 байгаа нь хувьсагчдын хоорондын хамаарал байгааг харуулж байгаа бөгөөд шинжилгээ хийх боломжтойг үзүүлж байгаа болно.

Хүчин зүйлсийн найдвартай байдлыг шалгах үүднээс хүчин зүйл тус бүрд найдвартай байдлын шинжилгээг хийж cronbach α тодорхойлоход Although Nunnally (1978) 0.7 дээш гарсан учир асуулга оновчтой боловсруулагдсан хэмээн үзээд шинжилгээг цааш үргэлжлүүлэн хийсэн. Хүчин зүйлсийн cronbach α -г (Хүснэгт 4)-д харуулав.

Хүснэгт 4. Хэмжил зүйн хувьсагчдын найдварт байдлын шинжилгээний үр дүн

Хүчин зүйл	Асуулгын тоо	Cronbach's α	Cronbach's α based on Standardized items
Энтрепренёр болох зорилго - EI	4	.772	.773
Хандлага - EA	4	.838	.832
Субъектив хэм хэмжээ - SN	3	.846	.846

Төсөөлсөн зан төлөвийн хяналт - ТРВ	6	.815	.816
Энтрепренёр боловсрол- ЕЕ	5	.811	.814
	22	.898	

Эх сурвалж: Судлаачийн тооцооллоор

Мөн нийт 22 асуултдаа найдвартай байдлын шинжилгээ хийж үзэхэд Кронбахын альфа нь .898 буюу уг хэмжүүрүүдийн найдвартай байдал болон шкалын оновчтой хэмжээ өндөр байгааг харуулж байна.

Хүчин зүйлсийн хоорондын хамаарлын шинжилгээ. Хүчин зүйлсийн хоорондын хамаарлыг тогтоохын тулд корреляцийн шинжилгээ хийсэн бөгөөд үр дүнг (Хүснэгт 5)-т харуулав.

Хүснэгт 5. Хүчин зүйлсийн хоорондын хамаарлын шинжилгээний үр дүн

Correlations						
		EI	EA	SN	ТРВ	ЕЕ
EI	Pearson Correlation	1				
	Sig. (2-tailed)					
EA	Pearson Correlation	.778**	1			
	Sig. (2-tailed)	.000				
SN	Pearson Correlation	.549**	.494**	1		
	Sig. (2-tailed)	.000	.000			
ТРВ	Pearson Correlation	.580**	.429**	.321**	1	
	Sig. (2-tailed)	.000	.000	.000		
ЕЕ	Pearson Correlation	.288**	.278**	.367**	.347**	1
	Sig. (2-tailed)	.000	.000	.000	.000	

** . Correlation is significant at the 0.01 level (2-tailed).

Эх сурвалж: Судлаачийн тооцооллоор

Шинжилгээгээр А сургуулийн суралцагчдын хувьд энтрепренёр болох зорилготой энтрепренёрт хандах хандлага [$r = .778$, $\rho < 0.01$] эерэг маш хүчтэй, төсөөллийн зан төлөвийн хяналт [$r = .580$, $\rho < 0.01$] болон субьектив хэм хэмжээ [$r = .549$, $\rho < 0.01$,] эерэг хүчтэй хамааралтай, энтрепренёр боловсрол [$r = .288$, $\rho < 0.01$] эерэг сул хамааралтай болох нь харагдаж байна.

Регрессийн шинжилгээ. Судалгааны таамаглалыг батлахын тулд хүчин зүйлсийн регрессийн шинжилгээг хийсэн бөгөөд үр дүнг (Хүснэгт 6)-т харуулав.

Хүснэгт 6. Хүчин зүйлийн регрессийн шинжилгээний үр дүн**Model Summary**

Model	R	R Square	Adjusted R Square	Std. Error of the Estimate
1	.717 ^a	.515	.509	2.36621

a. Predictors: (Constant), EE, EA, TPB, SN

ANOVA^a

Model		Sum of Squares	df	Mean Square	F	Sig.
1	Regression	1960.031	4	490.008	87.518	.000 ^b
	Residual	1847.658	330	5.599		
	Total	3807.690	334			

a. Dependent Variable: EI

b. Predictors: (Constant), EE, EA, TPB, SN

Coefficients^a


Model		Unstandardized Coefficients		Standardized Coefficients	t	Sig.
		B	Std. Error	Beta		
1	(Constant)	.774	.048		15.087	.000
	EA	.556	.047	.529	11.799	.000
	SN	.256	.059	.217	2.645	.000
	TPB	.259	.034	.209	4.644	.000
	EE	.130	.041	.114	1.741	.000

a. Dependent Variable: EI

Шинжилгээнээс харахад энтрепренёр болох зорилготой энтрепренёрт хандах хандлага, субъектив хэм хэмжээ, төсөөллийн зан төлөвийн хяналт, энтрепренёр боловсролын нөлөө зэрэг хүчин зүйлүүдийн хамаарал нь 50.9% (R Square=.509) байна.

Энтрепренёрт хандах хандлага [$\beta = .529$, $\rho < 0.01$] мэдэгдэхүйц, төсөөллийн зан төлөвийн хяналт [$\beta = .209$, $\rho < 0.01$], субъектив хэм хэмжээ [$\beta = .217$, $\rho < 0.01$], энтрепренёр боловсрол [$\beta = .114$, $\rho < 0.01$] нь сул нөлөө үзүүлдэг болох нь судалгааны үр дүнгээс харагдлаа. Судалгааны үр дүнг (Зураг 6)-т харуулав.

Зураг 6. Судалгааны ажлын үр дүн



Эх сурвалж: Судлаачийн тооцоолоор

Холбогдох зохицуулагч хувьсагчдын нөлөөлөл бүгд (Beta коэффициент) эерэг болон статистикийн ач холбогдолтой ($p < 0.01$) гарсан учраас таамаглал бүгд батлагдлаа.

Дүгнэлт

Шинэ бизнесийн байгууллагуудыг үүсгэн байгуулах нь шинэ үеийн залуусын нийгмийн чадамжтай холбоотой (Urbano.D., Toledank.N, 2008) бөгөөд тэдний мэдлэг, ур чадвар, хандлагын төвшин бүхий л салбарын ирээдүйг тодорхойлж байгаа учраас дэлхий даяар өсвөр үеийн залуусын энтрепренёрын зорилго түүнд нөлөөлөх хүчин зүйлс, энтрепренёр боловсрол, хандлагын талаарх судалгаа нилээдгүй хийгдэж байна.

Энэхүү судалгаа нь энтрепренёр болох зорилгод нөлөөлөх хүчин зүйлсийн талаарх өмнөх үеийн эрдэмтэдийн онол, загвар, судалгаан дээр үндэслэн судалгааны загвараа боловсруулан оюутан суралцагчдын энтрепренёр болох зорилгод нөлөөлж байгаа эсэхийг судалсан.

Судалгаанд бие даасан хувьсах хэмжигдэхүүнээр энтрепренёрийн талаарх хандлага, субъектив хэм хэмжээ, төсөөллийн зан төлөвийн хяналт, энтрепренёр боловсрол, хамаарах хувьсах хэмжигдэхүүнээр энтрепренёр болох зорилгыг сонгон авч хүчин зүйлийн, найдвартай байдлын, корреляцийн, регрессийн шинжилгээг хийн дэвшүүлсэн таамаглалаа батлахыг оролдлоо.

Хамраалын шинжилгээний үр дүнгээс харахад энтрепренёр болох зорилгод бүх хүчин зүйлс эерэг хамааралтай байсан бөгөөд энтрепренёр болох зорилготой энтрепренёрт хандах хандлага маш хүчтэй, төсөөллийн зан төлөвийн хяналт

болон субъектив хэм хэмжээ хүчтэй хамааралтай, харин энтрепренёр боловсрол сул хамааралтай байсан. Оюутнуудын энтрепренёр сэтгэлгээг хөгжүүлэхэд нөлөө үзүүлж болохуйц Бизнес ба нийгэм, Бизнес төлөвлөлт, Төслийн менежмент, Жижиг дунд үйлдвэрлэлийн менежмент хичээлүүдийг сонгон судалсан эсэх нь энтрепренёр болох зорилгод нөлөөлөх талаар авч үзэхэд Бизнес төлөвлөлт, Төслийн менежмент, Жижиг дунд бизнесийн менежмент хичээлүүдийн хувьд тус хичээлийг судалсан оюутнууд нь судлаагүй оюутнуудтай харьцуулбал энтрепренёр болох зорилго өндөр байсан бөгөөд эдгээр хичээлээр олж байгаа мэдлэг, ур чадвар тодорхой төвшинд оюутнуудыг бизнес эрхлэгч болох сэдэл, зорилгод нөлөөлж байгааг харуулсан. Харин Бизнес ба нийгэм хичээлийг сонгон судалсан оюутнуудын хувьд уг хичээлийг сонгон судлаагүй оюутнуудаас энтрепренёр болох зорилго доогуур түвшинд байсан.

Энтрепренёрт хандаж буй хувийн хандлага нь энтрепренёр болох зорилгод мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг болох нь судалгааны үр дүнгээс харагдсан. Энтрепренёрт хандах хандлага нэг нэгжээр нэмэгдэхэд энтрепренёр болох зорилго 0.529 (бетта) нэгжээр нэмэгддэг байна. Өөрөөр хэлбэл бизнес эрхлэх боломж л гарвал өөрийн бизнесээ эхлүүлэх хүсэл сонирхол оюутан залууст байгаа бөгөөд өөрийн гэсэн бизнестэй байх нь олон олон давуу талуудыг өөртөө бий болгодог хэмээн үзсэн байна. Эндээс дүгнэхэд судалгаанд хамрагдсан оюутнуудын хувьд бизнес эрхлэх талаар хандлага эерэг байна.

Субъектив хэм хэмжээ нь энтрепренёр болох зорилгод эерэг нөлөө үзүүлэх бөгөөд гэр бүл, ойр дотны хүмүүсийн нөлөө нэг нэгжээр нэмэгдэхэд энтрепренёр болох зорилго 0.217 (бетта) нэгжээр нэмэгддэг байна. Өөрөөр хэлбэл тухайн оюутныг бизнес эрхлэх зорилго өмнөө тавихад гэр бүл, найз нөхөд, ойр дотны хүмүүс нь бизнес эрхэлдэг юм уу, хувийн бизнес эрхлэх хандлага эерэг, бизнес эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх нь их чухал нөлөө үзүүлдэг байна.

Төсөөллийн зан төлөвийн хяналт энтрепренёр болох зорилгод эерэг нөлөө үзүүлдэг болох нь судалгааны үр дүнгээс харагдсан. Төсөөллийн зан төлөвийн хяналт нэг нэгжээр нэмэгдэхэд энтрепренёр болох зорилго 0.209 (бетта) нэгжээр нэмэгддэг байна. Өөрөөр хэлбэл бизнес эрхлэх нь саад бэрхшээлтэй ч түүнийг даван туулах мэдлэг, ур чадвар, туршлагыг хуримтлуулах нь өөртөө итгэх итгэл бий болгож энтрепренёр болох зорилгыг нэмэгдүүлж байдаг байна. Судалгаанд хамрагдсан оюутнуудын хувьд бизнес санаагаа хөгжүүлэхэд учрах саад бэрхшээл даван туулж чадна, хичээлвэл боломж бий хэмээн үзсэн байна.

Судалгааны үр дүнгээр судалгаанд хамрагдсан оюутнуудын хувьд шинийг санаачлах, чөлөөтэй сэтгэх, бизнес эрхлэх ур чадваруудад суралцах, өөрийн нөөц бололцоог нээн илрүүлэхэд дэмжлэг үзүүлдэг хичээлүүдийг судлах бүрд энтрепренёр болох зорилго 0.114 (бетта) нэгжээр нэмэгддэг байна.

Энтрeпрeнeр бoлoвсрoл нь энтрeпрeнeр бoлoх зoрилгoд үзүүлж бaйгaа нөлөө бусад хүчин зүйлсээс үзүүлэх нөлөө бaгa гaрсан бoлoвч их сургуулиас олгoж бaйгaа энтрeпрeнрийн тaлaарх мэдлэг, бoлoвсрoл нь oюутан суралцагчдын энтрeпрeнeр бoлoх зoрилгoд эерэг нөлөөлдөг бoлoх нь хaрaгдлaа.

Ашигласан ном

Монгол хэл дээр

- [1] Болор.Б, Цэрэндулам.Ш, 2017, “Энтрeпрeнeршип сэтгэлгээг төлөвшүүлэх зарим асуудал”, Хүний нөөцийн менежмент, 08, N° 44, хх.25-35
- [2] Дэлгэрбуян.Г, 2018, “МУИС- Бизнесийн сургуулийн оюутнуудын бизнес эрхлэх хүсэл сонирхол, хандлагын харьцуулсан судалгаа”

Англи хэл дээр

- [3] Ajzen, I, 1991 “The theory of planned behavior”, “Organizational Behavior and Human Decision Processes”, pp.179-211
- [4] Ajika, Emmanuel O, Akinlabi, Babatunde H., 2015, “Entrepreneurship Education and Entrepreneurial Intentions: the Role of Theory of Planned Behavior”, “International Journal of Advanced Research in Social Engineering and Development Strategies”, pp.118-135
- [5] Anh T.P. Tran, 2016, “A conceptual model of social entrepreneurial intention based on the social cognitive career theory”, “Asia Pacific Journal of Innovation and Entrepreneurship”, pp.17-38
- [6] Anurag Pahuja, 2015 “Introduction to Entrepreneurship”, “SSRN Electronic Journal” pp.1-40
- [7] Albert Bandura, “Self-Efficacy: The exercise of control”
- [8] Barbara Bird, 1988 “Implementing Entrepreneurial Ideas: The Case For Intention”, “ The Academy of Management Review” , pp.442-453
- [9] Christian Willi Scheiner, 2009 “Fundamental Determinants of Entrepreneurial Behavior”, “Gabler research” pp.5-32
- [10] Francis Chuaha, Hiram Tingb, Syed Ridhwan Alsreec, 2015 “Factors affecting entrepreneurial intention of malaysian university students”, “Conference on Business Management Research II” 81-94
- [11] Francisco Linen, Jan. Rodriguez-Chard, Jose M.Rueda-Cantuche, 2005 “Factors affecting entrepreneurial intention levels”
- [12] Francisco Linan, Yi-Wen Chen, 2009 “Deveolpment and cross-cultural application of a specific instrument to measure entrepreneurial intentions”, pp.593-617

- [13] Genc Alimehmeti, Gentjan Shaqiri, 2015, "Factors Determining Entrepreneurial Intentions: A Case Study from Albania", "Academic Journal of Interdisciplinary Studies", pp.233-240
- [14] Hitesh S.Viramgami, 2007, "Fundamentals of Entrepreneurship" pp.1-64
- [15] Kouros, Mohamad, Sharifi, Stephen, Levent, 2019 "Understanding entrepreneurial intentions: A developed integrated structural model approach"
- [16] Louis Jacques Filion, 2008 "Defining the Entrepreneur Complexity and Multi-Dimensional Systems Some Reflections", "World Encyclopedia of Entrepreneurship", pp.41-52
- [17] Marina Solesvik, 2013 "Entrepreneurial motivations and intentions: Investigating the role of education major", pp.253-271
- [18] Martin Lackeus, 2015 "Entrepreneurship in Education", "Background paper", pp.1-36
- [19] Mohammad Mizanur Rahman, 2017, "Entrepreneurship mindset for students entrepreneurship build-up", "International journal of multidisciplinary advanced scientific research and innovation" pp.26-34
- [20] Nadia Nazir Awan, Nawaz Ahmad, 2017, "Intention to become an entrepreneur: survey from university students of Karachi", "International Journal of Business, Economics and Law", pp.19-27
- [21] Nancy G. Boyd, George S. Vozikis, 1994 "The influence of Self-efficacy on the development of entrepreneurial intentions and actions" pp.63-77
- [22] Norris F. Krueger , 1993, "The impact of Prior Entrepreneurial Exposure on Perceptions of New Venture Feasibility and Desirability", "Entrepreneurship Theory and Practice" pp.56-91
- [23] Rita Remekiene, Grazina Startiene, Daiva Dumciuviene, 2013 "Explaining entrepreneurial intention of university students: The role of entrepreneurial education", pp.299-307
- [24] Salvador Gimeno Vidal, 2018, "Examining the entrepreneurial intention of university students: The role of entrepreneurial education and attitudes", "Grau en Administració d'Empreses", pp.420-480
- [25] Tatiana Lakoleva, Lars Kolvereid, 2009, "An integrated model of entrepreneurial intentions", "Int. J. business and globalization", pp.66-80
- [26] Wei-Loon Koe, Juan Rizal Sa'ari, Izaidin Abdul Majid, Kamariah Ismail, 2012 "Determinants of Entrepreneurial Intention Among Millennial Generation" pp.197-208

- [27] Zhengxia Peng, Genshu Lu, Hui Kang, 2012, “Entrepreneurial Intentions and Its Influencing Factors: A survey of the University Students in Xi’an China”, “Creative Education”, pp.95-100

Онлайн эх сурвалжууд:

[29] <http://www.businessdictionary.com>

[30] <https://dictionary.cambridge.org>